# Багийн ажил: Бэлтгэсэн зургууд бидэнд юу хэлж чадах вэ?

Энэ дасгал ажлыг баг болон хуваагдаж урьдчилан гаргасан зурагт дүн шинжилгээ хийж, санал сэтгэгдлээ өгөх юм. Дасгалын зорилго нь:

1. Урьдчилан бэлтгэсэн зурганд санал, удирдамж өгөх
2. REDD+-н төлөвлөлттэй холбоотой түлхүүр дүгнэлтүүдийг гаргахад газрын зураг хэрхэн ашиглагдаж болох талаар ойлголттой болох

**Дасгал ажлийн төлөвлөгөө:**

| Цаг | Үйл ажиллагаа |
|---|---|
| **13:15 – 13:20**<br>*5 мин* | **Дөр**<br>Тус бүр 10 хүний бүрэлдхүүнтэй 4 баг болон хуваагдаж :<br>1. Ойн бүсийн зураг: ойн боломжит нөлөөлөл<br>2. Ойн бүсийн зураг: олон талт боломжит үр ашиг<br>3. Төв аймгийн газрын зураг<br>4. Хөвсгөл аймгийн газрын зураг<br>2 аймгаас ирж оролцож байгаа оролцогчид тухайн аймгийг авсан багт орно.(бүлэг тус бурт өгөгдөх газрын зургийн жагсаалтийг доор дурдсан байна) |
| **13:20 – 14:00**<br>*40 мин* | **Алхам 2 - Анхны сэтгэгдэл**<br>Баг тус бүрт 4-5 газрын зураг өгнө. Эдгээр нь томоор хэвлэсэн зургууд байх бөгөөд зарим зураг нь хэрхэн хийгдсэн талаар мэдээллийг агуулсан байгаа.<br>Баг тус бүр дараах асуултанд хариулна<br>○ Энэ зургийн юу нь таньд таалагдаж байна вэ?<br>○ Санал нийлэхгүй эсвэл таалагдахгүй байгаа зүйл байна уу?<br>○ Энэ зургуудыг юунд ашиглаж болох вэ?<br>Асуулт болгонд өөр өөр өнгийн цаас ашиглан ханан дээр байгаа зургийн гадна талд наана. |
| **14:00 – 14:30**<br>*30 мин* | **Алхам 3 – Газрын зургаа солилцох**<br>Багууд байраа солино.<br>○ 1,2 р баг (Ойн бүсийн зураг) солигдоно<br>○ 3,4 р баг (Төв, Хөвсгөл аймаг) солигдоно<br>Баг тус бүр нөгөө багийн хариулсан хариултуудыг хараад дээрх гурван асуултанд өөрийн хариултыг нэмж болно. |
| **14:30 – 15:30**<br>*1 цаг* | **Алхам 4: Өөрсдийн хийсэн зураг руу буцах**<br>Баг тус бүр өөр өөрсдийн байрандаа ирж бусад баг юм нэмсэн байгаа эсэхийг шалгана.<br>Дараа нь тайлагнахдаа бэлдэж дараах 2 зүйлийг хэрэгжүүлнэ.<br>1.Нэмэлт асуултанд хариулах<br>• 1,2-р багийн асуулт: Аль газар ойн хомсдол болон ойн олон талт үр ашгийг харуулж байна вэ? |

| | |
|---|---|
| | • Ойн бүрхэвчийн зурган дээр эдгээрийг дугуйлаад яагаад гэдгээ бичнэ. Энэ асуултан дээр нөгөө багтайгаа хамтран ажиллах эсэхийг шийдээрэй!<br>• 3, 4 -р баг: Аль ойтой талбай нь олон төрлийн ойн үр ашгийг өгч байна вэ? (жишээ нь нэгээс илүү боломжит үр ашгийн тодорхойл)<br>• Тэдгээрийг ойн төрлийн зурган дээр дугуйлаад ямар үр ашгийг өгч байгааг тэмдэглэнэ.<br><br>2.Гурван түлхүүр дүгнэлтүүдийг бичих: цагаан цаасан дээр эдгээр өгөгдсөн зурагнууд юу хэлж байгаа талаар 3 түлхүүр дүгнэлт бичнэ. Энэ нь газрын зураг нь юуг харуулж байгаа талаар эсвэлилүү судалгаа шинжилгээ хийх шаардлагатай асуултууд ч байж болно. Газрын зургийн хажууд наана уу? |
| ***15:30 – 16:00***<br><br>*30 мин* | ***Алхам 5 - Цайны завсарлага (маш чухал!)*** |
| **16:00 – 16:45**<br><br>*45 мин* | **Алхам 6 - Тайлагнах**<br><br>Алхам 4-т хийсэн үр дүнгээ тайлагнах хүнээ сонгоно.<br><br>1.Сонгосон газар<br><br>2.3-н тулгуур дүгнэлт<br><br>Баг тус бүр 5-10 минутанд багтаана.<br><br>Асуулт асуух, хэлэлцүүлэх хугацаа олгоно. |